

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЖАРГАЛАНТ СУМЫН 3 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын код: ХОА-2021/4/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2021 он

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд

тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: Х

khovd@audit.gov.mn

Аудитын менежер:

Утас: 70432545 Цахим хаяг:

Тунгалаг бүртгэл Аудит ХХК

Аудитор: Ч.Мөнхцооз

Утас: 99028555

Цахим хаяг: munhuu8555@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	11
3. Аудитын тайлан .....	11
3.1. Ерөнхий зүйл .....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	12
3.4. Материаллаг байдал.....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.9. Аудитын илрүүлэлт .....	15
Залруулсан алдаа .....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	16
Аудитын зөвлөмж.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	16
4. Менежментийн захидал .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	17

## 1. ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
64000 Цэнхэржав бөс, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433081, Факс: 976-70433081  
E-mail: khovd@audit.gov.mn

ЖАРГАЛАНТ СУМЫН 3 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Ц.ГАНЦЭЦЭГ ТАНАА

2021.02.18 № 2/66  
таний \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЯДБААТАР

021020371

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**  
**2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>31,611,775.94</u></b>	<b><u>31,380,569.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	6,380,809.21	19,940.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	6,380,809.21	19,940.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	25,230,966.73	31,360,629.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	70,300.00	544,959.00
35130	Эм боох материал	70,300.00	544,959.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	25,160,666.73	30,815,670.00
35410	Бичиг хэргийн материал	40,000.00	40,000.00
35420	Аж ахуйн материал	340,728.75	176,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,590,000.00	3,290,000.00
35450	Барилгын засварын материал	1,631,350.00	1,631,350.00
35460	Хүнсний материал	2,375,517.98	1,360,451.00
35470	Бусад хангамжийн материал	18,183,070.00	24,317,869.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>688,246,838.43</u></b>	<b><u>678,347,671.85</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	688,246,838.43	678,347,671.85
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	633,746,888.51	623,961,971.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	620,547,058.95	630,447,058.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	(26,207,544.60)	(50,496,055.59)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	44,106,169.00	40,109,369.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(32,425,872.69)	(28,516,206.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,557,290.32	40,957,290.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,090,346.69)	(16,642,101.42)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,417,651.00	10,417,651.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,157,516.78)	(2,315,033.54)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	54,499,949.92	54,385,699.96
39301	Програм хангамж	457,000.00	457,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(114,250.08)	(228,500.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	54,157,200.00	54,157,200.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>719,858,614.37</u></b>	<b><u>709,728,240.85</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>144,615.74</u></b>	<b><u>37,232.44</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	144,615.74	37,232.44
<b>413</b>	<b>Өглөг</b>	144,615.74	37,232.44
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	144,615.74	37,232.44
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>719,713,998.63</u></b>	<b><u>709,691,008.41</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	719,713,998.63	709,691,008.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	222,076,478.00	222,076,478.00
51101	Өмч: - төрийн	222,076,478.00	222,076,478.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	308,907,055.86	300,397,681.11
51210	Өмнөх үеийн үр дүн	308,907,055.86	311,578,188.15
51220	Тайлант үеийн үр дүн	-	(11,180,507.04)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	188,730,464.77	187,216,849.30
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>719,858,614.37</u></b>	<b><u>709,728,240.85</u></b>

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>410,864,430.32</b>	<b>512,928,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>20,028,882.32</b>	<b>24,411,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	23,011,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	23,011,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	23,011,500.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	20,028,882.32	1,400,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	10,301,513.32	1,400,000.00
122002	Хандив тусламж /гадаад/	9,727,369.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>390,835,548.00</b>	<b>488,517,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	342,035,100.00	438,217,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	342,035,100.00	438,217,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2,394,500.00	-
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,694,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	700,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	46,381,400.00	50,300,000.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	46,381,400.00	50,300,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	24,548.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	24,548.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>437,291,788.16</b>	<b>524,109,307.04</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>437,291,788.16</b>	<b>524,109,307.04</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	437,241,788.16	490,187,063.23
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	252,885,763.88	339,971,638.46
210101	Үндсэн цалин	187,214,219.88	229,773,707.22
210102	Нэмэгдэл	37,488,166.00	86,273,360.24
210104	Урамшуулал	28,183,378.00	23,924,571.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,012,263.91	43,144,693.86
210201	Тэтгэврийн даатгал	21,909,139.47	29,402,414.62
210202	Тэтгэмжийн даатгал	2,525,781.11	3,441,668.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,020,624.88	2,752,914.94
210204	Ажилгүйдлийн даатгал	505,156.23	685,728.48

210205	Эрүүл мэндийн даатгал	5,051,562.22	6,861,967.14
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		
		41,108,534.00	43,973,671.80
210301	Гэрэл, цахилгаан	31,798,034.00	31,077,705.80
210303	Цэвэр, бохир ус	9,310,500.00	12,895,966.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		
		13,105,289.99	2,732,506.75
210401	Бичиг хэрэг	257,500.00	1,472,497.00
210402	Тээвэр, шатахуун	61,700.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	205,288.34	265,054.00
210404	Ном, хэвлэл	-	6,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	56,499.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	704,349.25	928,955.75
210408	Бараа материал акталсны зардал	11,759,953.40	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>		
		48,977,758.92	23,431,940.73
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	62,500.00	582,120.00
210502	Хоол, хүнс	46,496,739.92	21,462,764.98
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,418,519.00	1,387,055.75
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		
		1,952,510.00	1,372,928.20
210604	Урсгал засвар	1,952,510.00	1,372,928.20
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		
		382,500.00	626,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	382,500.00	50,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	576,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		
		46,817,167.46	34,933,683.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,827,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,956,550.00	284,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	34,033,617.46	34,649,683.43
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		
		50,000.00	33,922,243.81
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		
		50,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		
		-	33,922,243.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	33,922,243.81
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(26,427,357.84)</b>	<b>(11,180,507.04)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>8,291,261.02</b>	<b>-</b>

225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,291,261.02	-
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(8,291,261.02)	-
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(34,718,618.86)</b>	<b>(11,180,507.04)</b>

### 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>390,884,901.00</b>	<b>488,630,659.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>390,884,901.00</b>	<b>488,630,659.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	342,035,100.00	438,217,300.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,394,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,694,500.00	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>		
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	46,381,400.00	50,300,000.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>		
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	73,901.00	113,359.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>390,884,901.00</b>	<b>488,630,659.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>390,884,901.00</b>	<b>488,630,659.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>390,811,000.00</b>	<b>454,595,056.19</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		
210101	Үндсэн цалин	261,666,100.00	334,961,744.45
210102	Нэмэгдэл	176,449,382.00	202,885,651.19
210104	Урамшуулал	69,604,118.00	108,506,746.01
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		
210201	Тэтгэврийн даатгал	15,612,600.00	23,569,347.25
210202	Тэтгэмжийн даатгал	31,208,300.00	43,355,270.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,221,700.00	29,481,570.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,496,600.00	3,468,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,997,300.00	2,774,800.00
		499,400.00	693,600.00
		4,993,300.00	6,936,900.00

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	41,702,200.00	43,973,671.80
210301	Гэрэл, цахилгаан	32,016,100.00	31,077,705.80
210303	Цэвэр, бохир ус	9,686,100.00	12,895,966.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	640,000.00	6,461,552.00
210401	Бичиг хэрэг	159,000.00	919,799.00
210402	Тээвэр, шатахуун	94,500.00	1,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	154,601.00	265,054.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	27,200.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	204,699.00	5,214,999.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	48,172,600.00	23,098,186.74
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,900.00	1,164,779.00
210502	Хоол, хүнс	45,862,500.00	20,447,698.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,244,200.00	1,485,709.74
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,679,200.00	1,765,944.20
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	700,000.00
210604	Урсгал засвар	4,679,200.00	1,065,944.20
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	127,400.00	-
210702	Дотоод албан томилолт	127,400.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	485,300.00	687,889.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	485,300.00	111,889.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	576,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,129,900.00	290,798.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	200,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,929,900.00	290,798.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>73,901.00</b>	<b>34,035,602.81</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	73,901.00	113,359.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	73,901.00	113,359.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	33,922,243.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	33,922,243.81
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	=	=
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	225,526,478.00	188,730,464.77	330,585,635.50		744,842,578.27
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	3,517,651.00		3,517,651.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	225,526,478.00	188,730,464.77	334,103,286.50	-	748,360,229.27
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	(3,450,000.00)	-	-		(3,450,000.00)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(25,196,230.64)		(25,196,230.64)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	222,076,478.00	188,730,464.77	308,907,055.86	-	719,713,998.63
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	222,076,478.00	188,730,464.77	308,907,055.86	-	719,713,998.63
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,671,132.29		2,671,132.29
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	222,076,478.00	188,730,464.77	311,578,188.15	-	722,385,130.92
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(1,513,615.47)	-		(1,513,615.47)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(11,180,507.04)		(11,180,507.04)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	222,076,478.00	187,216,849.30	300,397,681.11	-	709,691,008.41

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	488517300.00	454595056.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	488517300.00	454595056.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	488517300.00	454595056.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	346843000.00	334961744.44
210101	Үндсэн цалин	204893100.00	202885651.19
210102	Нэмэгдэл	116388300.00	102926746.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2594900.00	5580000.00
210104	Урамшуулал	22966700.00	23569347.25

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	46823700.00	43355270.00
210201	Тэтгэврийн даатгал	32950000.00	29481570.00
210202	Тэтгэмжийн даатгал	3468400.00	3468400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2774800.00	2774800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	693600.00	693600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6936900.00	6936900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	48800000.00	43973671.00
210301	Гэрэл, цахилгаан	35777400.00	31077705.00
210303	Цэвэр, бохир ус	13022600.00	12895966.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	580000.00	6461553.00
210401	Бичиг хэрэг	123000.00	919799.00
210402	Тээвэр, шатахуун	61700.00	1700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	101,000.00	265,054.00
210404	Ном, хэвлэл	70,300.00	1.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	224,000.00	5,214,999.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	41,794,200.00	23,098,186.74
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,056,900.00	1,164,779.00
210502	Хоол, хүнс	38,353,600.00	20,447,698.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,383,700.00	1,485,709.74
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,643,400.00	1,765,944.20
210601	Багаж, техник, хэрэгсэл		700,000.00
210604	Урсгал засвар	1,643,400.00	1,065,944.20
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	127,400.00	144,000.00
210702	Дотоод албан томилолт	127,400.00	144,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	719,600.00	687,889.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,600.00	111,889.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,186,000.00	146,798.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,186,000.00	146,798.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	488,517,300.00	454,595,056.19
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	438,073,900.00	404,295,056.19
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	438,073,900.00	404,295,056.19
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	50,443,400.00	50,300,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	50,443,400.00	50,300,000.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	1.00	1.00
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	1.00	1.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	1.00	1.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>18.00</b>	<b>18.00</b>
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	18.00	18.00

## **2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

Нэмэлт санхүүжилтийн дансаар 113,3 мянган төгрөгийн НДсангийн тэтгэмжээс өөр гүйлгээ гараагүй байна.

## **3.Аудитын тайлан**

### **3.1. Ерөнхий зүйл**

Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, төсвийн зардлыг зөв бүртгэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 21-наас 2021 оны 01 дугаар сарын 25-ны хооронд Тунгалаг бүртгэл аудит ХХК-ны ахлах аудитор Ч. Мөнхцооз аудитор Ш.Оюунцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Цэцэрлэг хамт олноороо хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлж, хүүхэд хөгжүүлэх хичээл сургалтын үйл ажиллагааг бэлтгэл сайтай, чанар, үр дүнтэй зохион зохион байгуулж, чанарын ахиц гаргахад эцэг эх олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн хүүхэд бүрийг эх хэлээрээ зөв ярьж санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэн ярихад сургахыг зорилгоо болгон ажиллажээ. Дэвгүүлсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхэд ажлаа чиглүүлсэн байна. Үүнд:

- СӨБ-ын сайжруулсан хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, сургалтын үйл ажиллагааны бэлтгэл, чанар үр өгөөжийг сайжруулах, "Чадварлаг багш хөтөлбөрийн хүрээнд ажлын байрандаа хөгжих, чадваржих боломжийг бүрдүүлэх
- Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичигтэй болох, хүүхдэд ээлтэй аюулгүй орчин бүрдүүлэн, "Авьяас", "Номын гэгээ", "Хүүхэд бүр цэцэрлэгт" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар хүүхдийн хөгжлийг дэмжих
- Багш ажилтан бүр хувийн соёл ёс зүйг эрхэмлэн хариуцсан ажилдаа чин сэтгэлээсээ хандан, хүүхдийг ажиглаж, мэдлэг, чадвар, хандлагыг үнэлж, гарч байгаа ахиц өөрчлөлт, хүүхдийн давуу талыг илрүүлэх, эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийн хөгжил төлөвшлийн талаар мэдээлэх, ярилцах замаар эцэг эх асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх
- Хүүхдийн эрүүл ахуй,хоол хүнсний аюулгүй байдлыг анхаарч хүүхдэд ээлтэй ээлтэй орчин бүрдүүлэх зэрэг асуудлуудыг тодорхойлон хэрэгжүүлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай"
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот "бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай"
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай"
- Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот "Хоолны зардлын норматив тогтоох тухай"

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн удирдлага нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт,дотоод аудитын алба 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна. Мөн тус газраас Шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөрчил арилгах х арга хэмжээ авагдаагүй байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд БАГА гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1% хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 524816,6 мянган төгрөгөөс нэг хувиар тооцон 5248,1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10724,3 мянган төгрөгөөр буюу 1,5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материалын болон үндсэн хөрөнгийн дансдуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	6,380,809	19,940	(6,360,869)
Бараа материал	25,230,967	31,360,629	6,129,662
Үндсэн хөрөнгө	688,246,838	677,753,672	(10,493,167)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>719,858,614</b>	<b>709,134,241</b>	<b>(10,724,373)</b>
Өр төлбөр	144,616	37,232	(107,383)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	719,713,999	709,097,008	(10,616,990)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>719,858,614</b>	<b>709,134,241</b>	<b>(10,724,374)</b>

Мөнгөн хөрөнгө үлдэгдэлгүй, авлага дансны үлдэгдэл 6380,8 мянган төгрөгөөр буурсан нь илүү тооцоолж олгосон цалингийн авлага 398,6, нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт 4488,3, татварын албанд илүү төлсөн 1493,8 авлага барагдсантай холбоотой байна.

Бараа материал данс 6129,6 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь цар тахалтай холбоотой ариутгах бодис маск, хамгаалах хувцас зэргийн үлдэгдэл нэмэгдсэн болон утаанаас хамгаалах зориулалтаар 3955,0 мянган төгрөгийн үнэ бүхий 35 ширхэг цонхонд агаар шүүгч суулгасантай холбоотой байна.

Тайваны хүүхдийг ивээх сангаас үнэ төлбөргүйгээр хөнжил 25, гудас 25, углаа дэвсээ даавуу 25 ширхэг нийт 1412,5 мянган төгрөгийн үнийн дүн бүхий бараа материал нийлүүлснийг орлогод авч данс бүртгэлд тусгажээ. Аймгийн засаг даргын захирамжаар 380,0 мянган төгрөгийг маскийн үнэнд шилжүүлснийг бараа материалын данс дамжуулан хөндий орлого авч зардалд бүртгэжээ. Үүнийг аймгийн нэгдсэн тайлангаар тусгайлан авч үзэхээр болсон болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10493,1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант жилийн элэгдлийн 34649,6 мянган төгрөг ихээхэн нөлөө үзүүлж байгаа боловч аймгийн БСУГ-аас хөрөнгө оруулалтаар бэлтгэн нийлүүлсэн зөөврийн компьютер 2 ширхэг 3499,0 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авч данс бүртгэлд тусгажээ.

Жаргалант сумын ОНХС-аас санхүүжүүлэн цэцэрлэгийн гадна хүүхдийн тоглоом иж бүрдлээр нь бэлтгэн нийлүүлэх ажлыг шууд гэрээгээр БЭХТУЛГА ХХК гүйцэтгэж хүлээлгэн өгснийг данс бүртгэлд тусгасан байна. Мөн цэцэрлэгийн барилгын гадна бетон суурьтай төмөр баганатай 140м урттай, төмөр торон хашаа шинэчлэх ажлыг Ундрам Алт ХХК гүйцэтгэснийг данс бүртгэл тайланд тусгажээ.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 281 тоот тушаалаар 7695,8 мянган төгрөгийн үнийн дүн бүхий нам даралтын зуухыг Эрдэнэбүрэн сумын хүүхдийн цэцэрлэгт шилжүүлэхээр шийдвэрлэсэн тул данс бүртгэлээс хасаж шилжүүлсэн байна. 3 дугаар цэцэрлэг одоо цахилгаан халаалттай байна.

Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн нийт орлого өмнөх оноос 102177,7 мянган төгрөгөөр буюу 24.8 хувиар өссөн байна.

Үзүүлэлт	өмнөх оны	тайлант оны	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Улсын төсвөөс олгосон санхүүжилт	342,035,100	438,217,300	96,182,200
Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт	46,381,400	50,300,000	3,918,600
Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө	20,028,882	24,411,500	4,382,618
бусад орлого, санхүүжилт	2,419,048	113,359	(2,305,689)
<b>Үйл ажиллагааны орлогын дүн</b>	<b>410,864,430</b>	<b>513,042,159</b>	<b>102,177,729</b>

Өмнөх оны үзүүлэлтээс 1 эмчийн орон тоо нэмэгдсэнтэй холбоотой цалингийн зардал нэмэгдсэн болон Засгийн газрын 2019 оны 472 тоот тогтоолоор цалин нэмэгдэх шинэчлэл хийгдсэнтэй холбоотойгоор санхүүжилт нэмэгдэж санхүүжилтийн орлогод материаллаг өөрчлөлт гарсан байна.

Үзүүлэлт	өмнөх оны	тайлант оны	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Цалин хөлс нэмэгдэл урамшуулал НДШ	284,898,028	384,615,388	99,717,360
Байр ашиглалттай холбоотой зардал	41,108,534	43,978,366	2,869,832
Хангамж бараа материалын зардал	13,105,290	1,932,801	(11,172,489)
нормативт зардал	48,977,759	23,919,941	(25,057,818)
Бусад бараа үйлчилгээний зардал	49,152,177	36,334,567	(12,817,610)
бусад урсгал шилжүүлэг	50,000	34,035,603	33,985,603
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>437,291,788</b>	<b>524,816,666</b>	<b>87,524,878</b>

Нийт зардал өмнөх оноос 87524,8 мянган төгрөгөөр буюу 20 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс цалин хөлс, шимтгэлийн зардал 99717,3, бусад урсгал шилжүүлэг 12192,4 мянган төгрөгөөр буурсан материаллаг өөрчлөлт гарчээ. Энэ нь халаалтын хугацаа 1 сараар хойшилсон, цаг үеийн нөхцөл байдлын улмаас үйл ажиллагаа хязгаарлагдсантай хамааралтай байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 530635,9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 530635,9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 42118,6 мянган төгрөгөөр бууруулж 488517,3 мянган төгрөгөөр баталсан байна.

### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 28 арга хэмжээг санхүүжүүлэхээр 488517,3 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 438073,9 орон нутгийн төсвөөс 50443,4 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 438217,3 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 50300,0 мянган төгрөг, нийт 488517,3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 454595,1 мянган төгрөгийг зарцуулж 33922,2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлангийн хугацаанд нэмэлт дансаар ямар нэгэн гүйлгээ хийгдээгүй. Өмнөх онд тэтгэмжүүд, НДсангаас олгосон лист, хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмж зэрэг ажил гүйлгээнүүд орсон бөгөөд энэ жил шууд тухайн ажилтны хувийн дансанд орсон байна. Тухайлбал: 2 багш хөдөө орон нутагт тасралтгүй ажилласны тэтгэмжээр 6638,1 мянган төгрөг, 1 хүн өндөр насны тэтгэвэрт гарсны тэтгэмж 9460,6 мянган төгрөгийг тус тус олгожээ.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд хэрэгжүүлсэн горим сорилын дүнгээр алдаа зөрчил илэрсэнгүй.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ажиллагсадтай хийх тооцоо ихээхэн зөрүүтэй илэрхийлэгдсэн,хувь хүнээс худалдан авсан 638,5 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээний үнийн дүнгээс ХХОАТ суутган тооцоогүй зэрэг зөрчилд засаж сайжруулах, дахин давтахгүй байх зөвлөмж өгчээ. Уг зөвлөмжийн хэрэгжилт 90 орчим хувьтай байна. Тайлангийн хугацаанд ажиллагсадад нэмэгдэл хөлсийг зөрүүтэй тооцож олгосон зөрчил гарлаа.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 6316,9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2671,1 мянган төгрөгийн алдааг залруулж 360,8 мянган төгрөгийг алдаанд төлүүлэх акт тогтоож, 3 чиглэлийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

## Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Өнгөрсөн онд акталсан модон хашааны 1157516 төгрөгийн элэгдлийг хуримтлагдсан элэгдлийн дүнгээс хасаагүй

Мөн хашааны дахин үнэлгээний хэрэгжсэн нэмэгдэл 1513,6 мянган төгрөгийг тайланд тусгаагүй зэрэг 2671,1 мянган төгрөгийн алдааны залруулга хийлээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар илэрсэн 360,8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоою.

Үүнд:

Ажиллагсадад илүү тооцож 360796 төгрөгийг олгосон зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг авлага, төлбөрийн тооцоог хянах ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, заалттай нийцэхгүй, үнэн зөв бодий байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 360796 төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД:**

- а. Хүүхдийн хоолны хэмнэгдсэн зардлаас 380.0 мянган төгрөгийн маскийг Буянт үйлийн шим ХХК-нд нийлүүлсэн зэрэг асуудлыг аймгийн ТЕЗ-ын нэгдсэн тайланд аймгийн хэмжээнд авч үзэх шаардлагатай байна

## **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **Зардлын данстай холбоотой асуудал.**

**1.1 Илрүүлэлт:** Тус байгууллагын цалин болон нэмэгдэл урамшууллын хэмжээ өмнөх оноос 46859,3 мянган төгрөгөөр өссөн бөгөөд оны эцэст унаа хоол, түлшний хөнгөлөлтөд 5880,0 мянган төгрөг зарцуулж батлагдсан дүнгээс 3285,0 мянган төгрөг хэтэрсэн байна.

**Эрсдэл:** Төсвийг бодитойгоор төлөвлөж зөв зохистойгоор хуваарилах

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зарчмыг баримтлан ажиллах

**Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** анхаарч ажиллана

**2.1. Илрүүлэлт:** 2020 оны мөнгөн гүйлгээний болон орлого үр дүнгийн тайланд зардлын зүйл ангийг зөв тодорхойлж бүртгээгүйгээс тухайн зардлын дүн буруу илэрхийлэгдсэн

**Эрсдэл:** төсвийн гүйцэтгэлийг буруу тайлагнах

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 5.1.2-д төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг нагнасан байх гэснийг анхаарч ажиллахыг зөвлөв.

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвшөөрч байна.

3.1. **Илрүүлэлт:** Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу

**Эрсдэл:** тайлан буруу илэрхийлэгдэх, хуурамч зарлага гаргах

**Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллах

**Байгууллагаас өгсөн хариу тайлбар** Зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2020-01-25			ХОАГ-2021/170../СТА-.....
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэг</b>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Ажилчдад илүү цалин олгосон	360796	Акт тогтоов	Эрхлэгч Ня-бо	Ц.Ганцэцэг А.Цэнд-Аюуш
2	Унаа хоолны хөнгөлөлтөнд батлагдсан төсвийн зүйл ангийг хэтрүүлсэн	3285000	Зөвлөмж	Эрхлэгч Ня-бо	Ц.Ганцэцэг А.Цэнд-Аюуш
3	Өмнөх онд актлагдсан үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг бууруулаагүй	1157517	Залруулга	Эрхлэгч Ня-бо	Ц.Ганцэцэг А.Цэнд-Аюуш
4	Өмнөх оны Актлагдсан хөрөнгийн ДҮН-г бүртгэл тайланд тусгаагүй	1513615	Залруулга	Эрхлэгч Ня-бо	Ц.Ганцэцэг А.Цэнд-Аюуш
	ДҮН	6316928			

## **ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**